



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.28 № 147

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ
БУУДЛЫН ЗАХИРАЛ Л.БЯМБАСҮРЭН,
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
А.АМАРЗАЯА НАРТ

Зөрчлийг арилгуулах тухай

Үндэсний Аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Чингис хаан Олон улсын нисэх буудлын 2012 он болон 2013 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Чингис хаан Олон улсын нисэх буудал нь Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдагдаагүй албан тушаалтнуудад 2012 он болон 2013 оны эхний хагас жилд нийт 46.3 сая төгрөгийн шатахууны зардал олгожээ.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Агентлагийн даргаас бусад албан тушаалтнуудад шатахуун олгосон асуудлыг таслан зогсоох арга хэмжээ авч үр дүнгийн талаар 2013 оны 12 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан Олон улсын нисэх буудлын захирал Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч А.Амарзаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА

БИЧСЭН:

УАГ-ЫН САГ-ЫН 1-р хэлтсийн
Ахлах аудитор Ц.Сугармаа

БОДИТ БҮРТГЭЛ
АУДИТ
ХХК

Бодит бүртгэл аудит ХХК-ийн
захирал 3.Ганболд

ТАНИЛЦСАН:

Чингисхаан олон улсын
нисэх буудлын захирал

Л.БЯМБАСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ

Ерөнхий нягтлан бодогч
А.Амарзаяа